



**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**

**МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР**

---

**2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ  
2023 ОН**

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ  
МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР**

Тайлангийн хамрах хугацаа: 2023.01.01-2023.12.31

Тайлан илгээгч:


Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний  
газрын дарга



Х.Ган-Очир

Боловсруулсан:

Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний  
газрын шинжээч



Б.Цолмон-Эрдэнэ

2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023.12.27

Улаанбаатар хот

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай Засгийн газрын 2023 оны 106 дугаар тогтоол, “Яамны бүтцийн нэгжийн орон тоо, чиг үүрэг, албан тушаал, албан тушаалын чиг үүргийг шинэчлэн батлах тухай” Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны Б/47 дугаар тушаалын дагуу 2023 оны 4 дүгээр сарын12-оос бүтэц орон тоонд өөрчлөлт орж Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Статистик, мэдээллийн технологийн хэлтэстэй) нийт 10 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ба 2023 оны жилийн эцсээр 7 албан хаагч ажиллаж байна.

Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын албан хаагчид

№	Овог нэр	Албан тушаал
1	Х.Ган-Очир	Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга
2	А.Гэрэлт-Од	Хөгжлийн бодлого, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах шинжээч
3	Ц.Ууганбаяр	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан шинжээч
4	Б.Цолмон-Эрдэнэ	Салбарын үйл ажиллагааны дотоод аудит хариуцсан шинжээч
5	Н.Нарантуяа	Статистик, мэдээллийн технологийн хэлтсийн дарга
6	Б.Мөнхбаяр	Салбарын суурь судалгаа, статистикийн мэдээлэл хариуцсан шинжээч
7	Ц.Лхагвадорж	Сүлжээний аюулгүй байдал, дотоод сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар нь хууль тогтоомж, бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нэгдсэн тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргах, сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, шийдвэрийн биелэлтэд хяналт шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нэгдсэн тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргах, Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн зарцуулалтад дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, судалгаа хийх, мэдээллийн санг бий болгох үндсэн чиг үүрэг хэрэгжүүлдэг.

2023 онд тус яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас “Салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангах хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд дараах гүйцэтгэлийн зорилтуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

- Бодлогын баримт бичигт тусгагдсан Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах;

- Салбарын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах;

- Барилга, хот байгуулалт, газрын харилцаа, нийтийн аж ахуйн салбарт төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах;

- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах;

- Яам, агентлаг, харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах;

- Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах;

- Төсвийн тухай хуулийн хүрээнд харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, яамны Дотоод Аудитын Хороонд танилцуулан, шийдвэрлүүлэх;

- "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд салбарын үйл ажиллагааг цахимжуулах замаар төрийн үйлчилгээг үр ашигтай, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах;

- Салбарын өгөгдлийн сан, мэдээллийн системийн уялдаа холбоог нэгдсэн удирдлагаар хангах, харилцан мэдээлэл солилцох техникийн шийдэл болон технологи нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

- Мэдээллийн сан, сүлжээний аюулгүй байдал, техник, тоног төхөөрөмж, хэрэглээний программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах;

- Нээлттэй өгөгдлийг байгууллагын цахим хуудас болон "Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем"-д тогтоосон хугацаанд байршуулж, Салбарын статистикийн мэдээллийг тогтмол шинэчлэн, баяжуулж өгөгдлийн сан үүсгэн, мэдээллийг боловсруулж, хэрэглэгчдийг мэдээллээр хангах

Дээрх гүйцэтгэлийн 11 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 71 арга хэмжээ, ажил үйлчилгээг төлөвлөсөн.

Тайлант хугацаанд Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө, Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Засгийн газраас Барилгын салбартай холбоотой хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөр, төслүүд, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тусгагдсан стратегийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, харьяа байгууллагуудын үр дүнгийн гэрээний биелэлт, тайлан үйл ажиллагааны үр дүнд улирал бүр, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж тодорхой үр дүн гаргасан байна.

Тус газарт 2023 оны 01 сарын 02-ны өдрөөс 12 сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд нийт 333 албан бичиг ирж, манай газраас 264 албан бичгийг боловсруулан холбогдох байгууллага, иргэдэд хүргүүлсэн.

Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын албан хаагчдын сургалтад хамрагдсан тухай;

№	Сургалтын нэр	Зохион байгуулсан газар	Хугацаа	Оролцсон албан хаагчийн тоо
1	Монгол Улсын Дотоод Аудиторуудын Форум	"Монголын Үндэсний Дотоод Аудиторуудын Холбоо" ТББ	2023-11-15	2
2	Төрийн байгууллагын дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчдын сургалт-2023	Сангийн яам	2023-11-17	2
3	Улсын хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтийн тайлан боловсруулах сургалт	Эдийн засаг, хөгжлийн яам	2023-11-17	1
4	Журмын төслийн хэлэлцүүлэг	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар	2023-12-15	5
5	Журмын төслийн хэлэлцүүлэг	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар	2023-08-28	2



## ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

### БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

#### 2.1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт;

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, ҮАБЗ-ийн зөвлөмж, ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл зэрэг нийт 77 хууль, тогтоол, шийдвэрийн 158 заалтын хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж, Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг удирдлага болгон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Сайдын зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, тайланг сайдын 2023 оны 1/2388 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлэн, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем (<https://unelgee.gov.mn/>)-д байршуулан, баталгаажуулсан.

## Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ

/2023 оны эхний хагас жилийн байдлаар/

Бүгд		Шийдвэрийн төрлөөр										
		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ҮАБЗ-ийн зөвлөмж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	
Хяналтад авсан тогтоол шийдвэрийн тоо		77	6	12	5	1	4	2	21	4	21	1
Заалтын тоо		158	53	23	8	1	6	2	26	4	35	1
Үнэлгээ	Биелсэн /100%/	129	50	17	8	1	4	2	19	3	24	1
	Хэрэгжих шатанд /70%/	25	2	5	-	-	2	-	5	1	10	-
	Хэрэгжилт хангалтгүй /30%/	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хугацаа болоогүй	4	1	1	-	-	-	-	2	-	-	-
Үнэлгээ /хувь/		95,2	98,8	93,2	100	100	90	100	93,7	92,5	91,4	100

Хяналтад авсан 158 заалтын 129 нь “үр дүн гарсан” буюу 100%, 25 заалт “хэрэгжих шатанд” буюу 70%-ийн хэрэгжилттэй, хугацаа болоогүй 4 заалт, нийт хэрэгжилтийн дундаж 95,2 хувьтай үнэлэгдэв.

Барилга, хот байгуулалтын салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан нийт 77 тогтоол шийдвэрээс 2023 онд 19, 2022 онд 29, 2021 онд 13, 2020 онд 2, 2010-2019 онд 14 тус тус батлагдсан байна.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, ҮАБЗ-ийн зөвлөмж, ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэлээс гарсан хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор гаргахаар ажиллаж байна.

Барилга, хот байгуулалтын сайдын тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах ажлын хүрээнд:

Барилга, хот байгуулалтын Сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хооронд

батлан гаргасан нийт 111 тушаалыг хяналтад авч 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар хэрэгжилтийг нэгтгэн тооцлоо. Үүнээс 92 тушаал 100 хувь хэрэгжиж дууссан тул хяналтаас хассан. Ажил үргэлжилж байгаа нийт 19 тушаалын хэрэгжилтээс 70 хувийн хэрэгжилттэй 12, хугацаа болоогүй 7 арга хэмжээ тус тус байна. Хэрэгжилтийн дундаж хувь 96.1 хувьтай байна.

Яамны сар бүрийн үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэн боловсруулж, тайланг сар бүрийн 05-ны дотор Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем (<https://unelgee.gov.mn/>)-д баталгаажуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

## 2.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хийж гүйцэтгэхээр тусгагдсан 32 зорилтын 79 арга хэмжээний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явцад Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, 84.68 хувьтай, “Үр дүнд хүрсэн” гэж үнэлэн, Сайдын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн, тайланг сайдын 2023 оны 1/4876 тоот албан бичгээр болон цахимаар ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем (<https://unelgee.gov.mn/>)-д байршуулан, баталгаажуулсан.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний явцын үнэлгээ;

/2023 оны жилийн эцсийн байдлаар/

№	Бодлогын чиглэл	Нийт арга хэмжээний тоо	Үүнээс						Хэрэгжилт /хувь/
			100%	90%	70%	50%	30%	0%	
1	Хүний хөгжлийн бодлого	8	6	-	1	1	-	-	
2	Эдийн засгийн бодлого	51	31	1	10	4	5	-	
3	Засаглалын бодлого	3	3	-	-	-	-	-	
4	Ногоон хөгжлийн бодлого	7	6	-	1	-	-	-	
5	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	10	4	1	2	2	1	-	
	Дүн	79	50	2	14	7	6	-	84.68

## 2.3. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-нд туссан Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 3 бодлого, 8 зорилгын хүрээнд нийт 34 арга хэмжээ, үүнээс 15 арга хэмжээний үндсэн хэрэгжүүлэгчээр, 19 арга хэмжээний хамтран хэрэгжүүлэгчээр ажилласан байна. “Монгол Улсын хөгжлийн 2023 оны

төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 95.59 хувьтай, "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдэв. Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 34 арга хэмжээнээс хэрэгжилт 100%-тай 29, 90% -3; 70%-тай -0; 50%-тай -1; 30%-тай -1 арга хэмжээ байна. Барилга, хот байгуулалтын Сайдын зөвлөлийн хуралдаанаар 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хэлэлцүүлэн, тайланг 2023 оны 1/4881 тоот албан бичгээр Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлэн, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем (<https://unelgee.gov.mn/>)-д байршуулан, баталгаажуулсан.

**"Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"-нд туссан зорилт, арга хэмжээний явцын үнэлгээ**

/2023 оны жилийн эцсийн байдлаар/

№	Бодлогын зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт /хувь/
1	1.1.5.1. Хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулах	Ашиглалтад орох сургуулийн тоо-36	100
2	1.1.5.2. Хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулах	Ашиглалтад орох цэцэрлэгийн тоо-48	100
3	1.1.6.2. Суралцагч тухтай орчинд суралцаж, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх орчныг бүрдүүлэх	Ашиглалтад оруулах дотуур байрны тоо	100
4	1.1.6.3. Суралцагч тухтай орчинд суралцаж, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх орчныг бүрдүүлэх	Шинээр барих болон өргөтгөх спорт заалны тоо	100
5	1.1.6.5. Суралцагч тухтай орчинд суралцаж, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх орчныг бүрдүүлэх	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах цэцэрлэг, сургууль, дотуур байрны тоо	100
6	1.6.1.2. Үндэсний бахархал, өв соёлыг сурталчлан таниулж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборын барилгын ажлын явц, хувиар-100	100
7	1.6.2.4. Үндэсний бахархал, өв соёлыг сурталчлан таниулж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих	Ашиглалтад орох соёл урлагийн байгууламж, музей болон номын сангийн тоо	100
8	2.2.1.3. Боомтуудын зорчигч болон ачаа нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх дэд бүтэц, барилга байгууламж барих	Замын-Үүд эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн дэд бүтэц, барилгын ажлын явц, хувиар-100	100
9	2.4.4. Арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн түүхий эдийг дотооддоо үйлдвэрлэх барилгын материалын үйлдвэрүүд барих	Ашиглалтад орох үйлдвэрийн тоо-7	100
10	2.6.1.1. Соёлын өв, үнэт зүйлийг сурталчлан таниулах музей, театрын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх	"Чингис хаан" хаад, язгууртны шинэ музейн тохижилтын ажлын явц, хувиар -100	100
11	2.6.1.2. Соёлын өв, үнэт зүйлийг сурталчлан таниулах музей, театрын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх	Байгалийн түүхийн шинэ музейн барилгын ажлын явц, хувиар- 40	100
12	2.6.1.3. Соёлын өв, үнэт зүйлийг сурталчлан таниулах музей, театрын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх	Улсын драмын эрдмийн театрын барилгын хүчитгэлийн	100



		ажлын явц, хувиар -100	
13	2.6.1.4. Соёлын өв, үнэт зүйлийг сурталчлан таниулах музей, театрын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх	Үндэсний номын сангийн барилга угсралтын ажлын явц, хувиар-100	100
14	2.6.1.5. Соёлын өв, үнэт зүйлийг сурталчлан таниулах музей, театрын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх	Үндэсний археологи, угсаатны зүйн музей, лабораторийн барилга угсралтын ажлын явц, хувиар-40	100
15	5.1.1.2. Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх төслүүд хэрэгжүүлэх	"Орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл" төслийн явц, хувиар-30	100
16	5.1.1.3. Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх төслүүд хэрэгжүүлэх	"Залуус-1" орон сууцны хороолол барих төслийн явц, хувиар-10	100
17	5.1.1.4. Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх төслүүд хэрэгжүүлэх	"Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл"-ийн явц, хувиар-70	90
18	5.1.1.5. Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх төслүүд хэрэгжүүлэх	"Солонго-1", "Солонго-2" орон сууцны хороолол барих төслийн явц, хувиар	30
19	5.1.2. Бага, дунд орлоготой иргэдийг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах	Орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдах иргэдийн тоо	100
20	5.1.3.1. Шинэ суурьшлын бүс, чөлөөт бүсийн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх	Хөшигийн хөндийн "Шинэ Зуунмод" хотын төлөвлөлтийн хүрээнд боловсруулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө	100
21	5.1.3.2. Шинэ суурьшлын бүс, чөлөөт бүсийн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэн, зураг төслийг боловсруулах объектын тоо	100
22	5.1.3.3. Шинэ суурьшлын бүс, чөлөөт бүсийн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх	"Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц" төслийн явц, хувиар	100
23	5.1.5.1. Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	Улаанбаатар хотын ус хангамжийг урт хугацаанд тогтвортойгоор нэмэгдүүлэх төслийн явц, хувиар	100
24	5.1.5.2. Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг барих төслийн явц, хувиар	90
25	5.1.5.3. Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	Улаанбаатар хотын инженерийн шугам, үерийн ус зайлуулах шугам, цэвэр, бохир усны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх ажлын явц, хувиар	100
26	5.1.6.1. Хот доторх авто зам, явган хүний зам болон дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн	Хот доторх авто зам шинээр барих, өргөтгөх ажлын явц, хувиар	100

	амьдрах орчныг сайжруулах		
27	5.1.6.2. Хот доторх авто зам, явган хүний зам болон дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдрах орчныг сайжруулах	Шинээр барих дугуйн зам, км	100
28	5.1.6.3. Хот доторх авто зам, явган хүний зам болон дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдрах орчныг сайжруулах	Шинээр барих явган хүний зам, м2	100
29	5.1.6.4. Хот доторх авто зам, явган хүний зам болон дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдрах орчныг сайжруулах	Гудамж, талбайн тохижилт хийх ажлын явц, хувиар	100
30	5.2.1.1. Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	Аймгийн төв, суурин газрын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийн явц, хувиар -80	90
31	5.2.1.2. Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	"Сумын хөгжил" арга хэмжээний хүрээнд инженерийн дэд бүтэц байгуулах сумын тоо -18	50
32	5.2.1.3. Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	Инженерийн шугам, үерийн ус зайлуулах шугам, цэвэр бохир усны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх ажлын явц, хувиар-100	100
33	5.2.1.4. Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох ажлын явц, хувиар-100	100
34	5.2.3.2. Сум, суурин доторх авто зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, гудамж гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн тав тухтай амьдрах орчныг сайжруулах	Сум, суурин доторх гудамж, талбайн тохижилт хийх ажлын явц, хувиар -100	100
<b>Нийт үнэлгээ</b>			<b>95.59%</b>

2.4 Барилгын салбарт төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрүүд, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт

Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2019-2029/-ний 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийн 8 зорилт, 25 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гарган, яамны нэгдсэн тайланд нэгтгэн 2023 оны 02-р сарын 27-ны 1/677 албан тоотоор ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем (<https://unelgee.gov.mn/>)-д баталгаажуулсан.

“150 мянган айл-Орон сууц” үндэсний хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг нэгдсэн тайланд хавсарган, 2023 оны 02-р сарын 27-ны 1/677 албан тоотоор

ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем (<https://unelgee.gov.mn/>)-д баталгаажуулсан.

Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гарган, хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайланг 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 1/688 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тайланг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох тэмдэглэл, шийдвэрийн хамт 2023 оны 02-р сарын 27-ны 1/677 албан тоотор ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем (<https://unelgee.gov.mn/>)-д баталгаажуулсан.

Яамны болон харьяа байгууллагуудын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн ажилд хяналт шинжилгээ үнэлгээ хийж тайланг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох тэмдэглэл, шийдвэрийн хамт 2023 оны 02-р сарын 27-ны 1/677 албан тоотор ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем (<https://unelgee.gov.mn/>)-д баталгаажуулсан.

## 2.5. Харьяа байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Төсвийн ерөнхийлөн захирагчтай Төсвийн шууд захирагч Төрийн орон сууцны корпорац /ТОСК/, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Барилгын хөгжлийн төвийн 2023 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө буюу байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт болон тус яамны дотоод газар, нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Удирдлагын Зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанаас гарсан шийдвэр, зөвлөмж, үнэлгээ, дүгнэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

№	Газрууд	Зорилтын тоо	Нийт арга хэмжээ	Хэрэгжилт хувиар						ДҮН
				100%	90%	70%	50%	30%	0%	
1	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар	88	245	183	32	26	3	1	0	94.6
2	"Барилгын хөгжлийн төв" төөаатүгазар	35	59	37	12	8	2	-	-	92.2
3	"Төрийн орон сууцны корпораци" төххк	30	61	48	2	8	2	0	1	92.4

## БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

2.6. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу Барилга, хот байгуулалтын яамны Төсвийн шууд захирагчийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагчаар хянуулж баталсан байна.

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай Засгийн газрын 2020 оны 104 дүгээр тогтоолын дагуу Барилга, хот байгуулалтын яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь дараах 6 тэргүүлэх чиглэл болох:

- Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулах;
- Барилга, инженерийн дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;
- Санхүү, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;
- Төрийн захиргааны удирдлага, хүний нөөцийн манлайллыг хангах, салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих;
- Салбарын хяналтын үр нөлөөг дээшлүүлэх;
- Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлэх, удирдлагаар хангах чиглэлийн хүрээнд стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан, шалгуур үзүүлэлт, зорилтыг тодорхойлж, тухайн жилийн хүрэх түвшин, гүйцэтгэл үр дүнг тооцсон байна.

Барилга, хот байгуулалтын яамны ТШЗ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 46 зорилтын 362 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2023 жилийн эцсийн байдлаар **95.4 хувийн** гүйцэтгэлтэй “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэлэв.

#### ГУРАВ. ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР

Барилга, хот байгуулалтын сайдын дэргэдэх “Дотоод аудитын хороо”-ны бүрэлдэхүүнийг Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 180 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.

Дотоод аудитын хороо нь 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдөр хуралдан, Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Дотоод аудитын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Дотоод аудитын хороо нь 2023 онд дараах дотоод аудитыг зохион байгуулсан.

3.1. “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын Норм, нормативын сангийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит;

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/31 дүгээр тушаалаар Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар газар дээр нь хяналт шалгалт хийж, дүгнэлт, үнэлгээ өгөх үүрэг бүхий Ажлын хэсгийг томилсон.

Ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр ажлын хэсгийн дарга баталсан. Төлөвлөгөөнд тусгасан Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2 зөвлөмжийн 15 заалт, барилга байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгийн зарцуулалт, тайлагналтыг 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар хэрэгжилтийг тооцсон.

Барилга, байгууламжийн норм, нормативын сангийн зарцуулалтад 2022 онд нийт 2.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр сангийн удирдах зөвлөлөөр батлагдсан бөгөөд 4.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн, зардалд 4.96 тэрбум төгрөг зарцуулахаар батлагдсан бөгөөд 1.5 тэрбум төгрөгийг зарцуулж санхүүгийн үйл ажиллагааг байгууллагын нийт үйл ажиллагааны хүрээнд хамруулан Үндэсний аудитын газраар 2023 онд хянуулан баталгаажуулсан байна. 2023 онд 2.3 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээс 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 1.2 тэрбум төгрөг төвлөрүүлж, орлогын гүйцэтгэл 52 хувьтай, 6.2 тэрбум төгрөг зарцуулахаас 681.7 сая төгрөгийг санхүүжүүлж, зардлын гүйцэтгэл 11 хувьтай байна.

Ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн “Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө”-г боловсруулан 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, 2023 оны 8/2265 тоот албан бичгээр “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ болон холбогдох газруудад хүргүүлсэн.

3.2. БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих” төслийн хэрэгжилтэд дотоод аудит;

Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 100 дугаар тушаалаар хяналт шалгалт, дотоод аудит хийх ажлыг хэсгийг батлуулж, БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих” төслийн хэрэгжилтэд дотоод аудитыг 2022 оны 05 дугаар сарын 08-аас 22-ны өдрүүдэд хийж гүйцэтгэн удирдлагад танилцуулан 7 дүгнэлт, 10 зөвлөмжийг гарган 2023 оны 05 дугаар сарын 29-ны 8/1991 тоот албан бичгийг төслийн нэгж болон холбогдох байгууллагад хүргүүлсэн.

3.3. Авлигатай тэмцэх “Шүүр” ажиллагааны хүрээнд яам, агентлаг болон төрийн өмчит компанид Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан шаардлагыг зөрчсөн үйлдэл, шийдвэрийг шалган тогтоож, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 51 дүгээр тушаалаар “Шүүр” ажиллагааны хүрээнд яам болон сайдын эрхлэх хүрээний агентлаг болон төрийн өмчит компанид Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан шаардлагыг зөрчсөн үйлдэл, шийдвэрийг шалган тогтоож, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг томилсон. Ажлын хэсгээс Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалангаас ирүүлсэн “Чиглэл хүргүүлэх тухай” 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн ХЭГ/595 тоот албан бичигт заасан 11 чиглэлийн хүрээнд барилга, хот байгуулалтын салбарын 13 байгууллагын нийт 480 ажилтан, албан хаагчдын хувийн хэрэг, боловсролын баримт бичиг, холбогдох тушаал, шийдвэрийг

газар дээр нь очиж нэг бүрчлэн үзлэг, шалгалтыг хийснээс нийт 26 ажилтан, албан хаагчидтай холбоотой зөрчил илэрч, “Шүүр” ажиллагаа явуулсан тухай илтгэх хуудсыг сайдын 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 1/1202 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

3.4. Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах;

Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 01-р сарын 25-ны өдрийн 14 дүгээр тушаалаар Барилга, хот байгуулалтын яам болон Төрийн бус байгууллагууд хооронд төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг томилсон.

“Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 18, 21, 22, 23 дугаар тушаалаар 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр байгуулагдсан гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн олголт, барилгын салбарын ажилтан, архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох болон Хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлээр хариуцсан төрийн бус байгууллагууд дээр ажиллаж, дүгнэлт, зөвлөмж гаргаж, ажлын хэсгийн тайланг 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан.

3.5 Бүгд Найрамдах Польш Улсын хөнгөлөлтэй зээлээр хэрэгжиж байгаа “Аймгуудын бохир усны цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэн, шинээр барих төсөл”-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлд дотоод аудит;

Барилга, хот байгуулалтын сайд, дотоод аудитын хорооны даргын баталсан “Дотоод аудитын ажлын удирдамж”-ын дагуу Бүгд Найрамдах Польш Улсын хөнгөлөлтэй зээлээр хэрэгжиж байгаа “Аймгуудын бохир усны цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэн, шинээр барих төсөл”-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлд дотоод аудитыг хийж “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгсөн.

3.6 Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит;

Барилга, хот байгуулалтын сайд, дотоод аудитын хорооны даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр баталсан “Дотоод аудитын ажлын удирдамж”-ын дагуу “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар”-ын санхүү, төсвийн үйл ажиллагаанд 2023 оны 11 дүгээр сарын 06-аас 17-ны өдрүүдэд дотоод аудитыг хийж “Хангалттай” гэсэн дүгнэлтийг өгсөн.

3.7 “Ногоон нуур-1008 айлын орон сууц төсөл”-ийн хэрэгжилтэд дотоод аудит хийх;

Барилга, хот байгуулалтын сайд, дотоод аудитын хорооны даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр баталсан “Дотоод аудитын ажлын удирдамж”-ын дагуу БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа “Ногоон нуур-1008 айлын орон

сууцны төсөл"-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлд 2023 оны 11 дүгээр сарын 06-аас 24-ний өдрүүдэд дотоод аудитыг хийж дүгнэлт, зөвлөмж гаргаж тайлагнасан.

3.8 Барилга байгууламжийн норм, нормативын сангийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн явцад 2023 оны 3-р улирлын байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;

Барилга байгууламжийн норм, нормативын сангийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн явцыг 2023 оны 3-р улирлын байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Барилгын хөгжлийн төвд 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 3/4089 албан тоотор хүргүүлэв. 2023 онд нийт 180 ажил төлөвлөж үргэлжлэн хийгдэх 102 ажлын гүйцэтгэл 83%, шинээр тусгагдсан 48 ажлын гүйцэтгэл 71,3%, нэмэлт 30 ажлын гүйцэтгэл 52%-тай нийт ажлын гүйцэтгэл дунджаар 68,7%-тай үнэлэгдэв. 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн Сайдын зөвлөлийн хуралд танилцуулсан.

3.9 “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл-МОНГ3244”-ийн төслийн хэрэгжилтэд дотоод аудит хийх;

Барилга, хот байгуулалтын сайд, дотоод аудитын хорооны даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр баталсан “Дотоод аудитын ажлын удирдамж”-ын дагуу Азийн хөгжлийн банкны хөнгөлөлтэй зээлээр хэрэгжиж байгаа “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН3244 төсөл” дуусаж байгаатай холбогдуулан үйл ажиллагааны гүйцэтгэлд 2023 оны 11 дүгээр сарын 06-аас 12 дугаар сарын 01-ны өдрүүдэд дотоод аудитыг хийж дүгнэлт, зөвлөмж гаргаж тайлагнасан.

3.10 Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах “Эко яармаг-1” төслийг хэрэгжүүлж буй “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх;

Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 11-р сарын 27-ны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/67-р тушаалаар “Эко яармаг-1” төслийг хэрэгжүүлж буй “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хариуцлагатай хувьцаат компанийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг 11-р сарын 27- 12-р сарын 8-ны хооронд хийж, 9 дүгнэлт, 11 зөвлөмж гарган тайлагнасан.

3.11 Өргөдөл гомдолд цаг хугацаад нь хариу өгч холбогдох арга хэмжээ авч байгаа эсэхэд хяналт-шинжилгээ хийх;

Барилга, хот байгуулалтын яам, албан тушаалтанд иргэдээс 2023.01.01-ний өдрөөс 2023.08.30-ны өдөр хүртэл хугацаанд бичгээр 115 өргөдөл, гомдол ирүүлсэн байна. Үүнээс хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн 96, хугацаа хэтэрсэн 3, судлагдах шатандаа 16 өргөдөл, гомдол байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 93,2% -тай дүгнэв. Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан тус яаманд 335 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд үүнээс 68,4% -ийг нь шийдвэрлэсэн, 31%-ийг харьяалах байгууллагад шилжүүлсэн, 7 өргөдөл судлагдах шатандаа байна. Үүнээс 3 өргөдлийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах Хороонд харьяаллын дагуу шилжүүлж, 4 өргөдөл шийдвэрлэх шатандаа, 11-11 төвд ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц 99,4% -тай дүгнэж тайланг

Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн шуурхайд танилцуулсан.

## ДӨРӨВ. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/12 дугаар тушаалын дагуу сар бүр оруулах мэдээлэлд хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.2 дахь хэсэгт заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын багцын мэдээллүүдийг нэгтгэн 1-р улирлын тайланг 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр, 2-р улирлын тайланг 2023 оны 7 дугаар сарын 28-ний өдөр 8/2730 албан тоотоор, 3-р улирлын тайланг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 8/3654 албан тоотоор тус тус хүргүүлсэн. Мөн тайланг Сангийн яамны <https://info.shilendans.gov.mn/> шилэн дансны цахим системээр цаг тухайд нь илгээсэн.

## ТАВ. ТӨСӨВ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар Барилга, хот байгуулалтын Сайдын багцын хүрээнд урсгал төсөв 42.3 тэрбум. Улсын төсвийн хөрөнгө оруулалт 345.2 тэрбум төгрөгөөр тус тус батлагдсан.

2023 оны 12 дугаар сарын 28-ны байдлаар урсгал төсөв 37.5 тэрбум төгрөг буюу 88.7 хувь, улсын төсвийн хөрөнгө оруулалт 336.9 тэрбум төгрөг буюу 97.6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. УИХ-ын 2021 оны 88 дугаар тогтоолын дагуу материалын үнийн өсөлт тооцогдож 2023 оны төсөвт 40.2 тэрбум төгрөгийн нийт 106 төсөл арга хэмжээнээс 72 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг Сангийн Яаманд хүргүүлж, өссөн дүнгээр 23.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдоод байна.

Монгол Улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулж, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг бэлтгэн гаргаж хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлэхээр ажиллаж байна.

## ЗУРГАА. ДҮГНЭЛТ

Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын 2023 гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 95.9 хувьтай, “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэлээ.

Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын  
2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт



/2023 оны жилийн эцсийн байдлаар/

Д/д	Гүйцэтгэлийн зорилт	Арга хэмжээ ний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээ
<b>Салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх стратегийн зорилгын хүрээнд:</b>			
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах	9	98
2	Салбарын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах	2	100
3	Барилга, хот байгуулалт, газрын харилцаа, нийтийн аж ахуйн салбарт төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах	2	95
4	Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах	8	99
<b>Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлыг хангах стратегийн зорилгын хүрээнд:</b>			
5	Яам, агентлаг, харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах	19	97
6	Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах	5	90
7	Төсвийн тухай хуулийн хүрээнд харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, яамны Дотоод Аудитын Хороонд танилцуулан, шийдвэрлүүлэх.	6	100
<b>Салбарын статистик, суурь судалгааг боловсруулах, хөгжүүлэх, мэдээлэл, технологийг нэвтрүүлэх, цахим шилжилтийг идэвхжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд</b>			
8	"Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд салбарын үйл ажиллагааг цахимжуулах замаар төрийн үйлчилгээг үр ашигтай, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангана.	4	90
9	Салбарын өгөгдлийн сан, мэдээллийн системийн уялдаа холбоог нэгдсэн удирдлагаар хангах, харилцан мэдээлэл солилцох техникийн шийдэл болон технологи нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.	7	90
10	Мэдээллийн сан, сүлжээний аюулгүй байдал, техник, тоног төхөөрөмж, хэрэглээний программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангана.	4	100
11	Нээлттэй өгөгдлийг байгууллагын цахим хуудас болон "Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем"-д тогтоосон хугацаанд байршуулж, Салбарын статистикийн мэдээллийг тогтмол шинэчлэн, баяжуулж, өгөгдлийн сан үүсгэн, мэдээллийг боловсруулж, хэрэглэгчдийг мэдээллээр хангана.	5	96
<b>Нийт дүн</b>		<b>71</b>	<b>95.9</b>

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ  
МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР